

2026 ОНЫ 2 ДУГААР САР

## НИЙСЛЭЛИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ БА БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Д. Баярмаа<sup>1</sup>

Нийслэлийн Засаг даргаас 2025.11.20-нд өргөн мэдүүлсэн Нийслэлийн 2026 оны төсвийн төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2025.12.5-нд баталсан. Энэхүү судалгааны хүрээнд Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд харьцуулсан дүн шинжилгээ хийж, тойм дүгнэлт боловсрууллаа.

### НИЙСЛЭЛЭЭС 2026 ОНД 4.1 ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛНЭ.

Нийслэлийн 2026 оны төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг нийт 4.1 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

#### Хүснэгт 1. Нийслэлийн 2026 оны хөрөнгө оруулалтын зардал, эх үүсвэрээр (тэрбум төгрөг)

Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	98	132	<b>+34</b>	12,321.9	12,499.9	<b>+178.0</b>	1,668.7	1,745.5	<b>+76.8</b>
Нийслэлийн Замын сангийн хөрөнгө оруулалт	56	58	<b>+2</b>	2783.6	2792.3	<b>+8.7</b>	227.9	227.9	-
Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	3	3	-	1,998.8	1,998.8	-	1,301.0	1,301.0	-
Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	70	70	-	17.0	17.0	-	17.0	17.0	-
Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт							34.0	34.0	-
Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт							80.0	-	<b>-80.0</b>
Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин санхүүжих хөрөнгө оруулалт	291	288	<b>-3</b>	10,704.1	12,829.4	<b>+2,125.3</b>	749.1	749.2	<b>+0.1</b>
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин санхүүжих хөрөнгө оруулалт	30	30	-	18.4	18.4	-	12.2	12.1	<b>-0.1</b>

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

<sup>1</sup> Талархал: Тойм дүгнэлтэд санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд талархал илэрхийлж байна.

Үүнд, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 12.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 132 төсөл, арга хэмжээг 1.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан. Мөн Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2.8 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 58 төсөл, арга хэмжээг 227.9 тэрбум төгрөгөөр, Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг 1.3 их

наяд төгрөгөөр, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээг 17 тэрбум төгрөгөөр, Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг 34 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлнэ. Мөн 2025-2026 он дамжин санхүүжих 318 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 761.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан.

## НИЙСЛЭЛИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

**Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 34-өөр, нийт төсөвт өртөг 178 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох санхүүжилтийн дүн 76.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 12.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 132 төсөл, арга хэмжээнд 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ. Үүнээс 838.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжих 79 төсөл, арга хэмжээг 583.9 тэрбум төгрөгөөр, 11.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 53 шилжих төсөл, арга хэмжээг 1.16 их наяд төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр баталсан байна. 2026 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртгийн 93.3 хувь, тухайн онд санхүүжих дүнгийн 66.5 хувь шилжих төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх жилээс

шилжиж ирсэн төслүүдэд төвлөрч байгааг харуулж байна.

Төсвийн төсөлтэй харьцуулахад нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 34-өөр, нийт төсөвт өртөг 178 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 76.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ. Үүнд, шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 29-өөр, нийт төсөвт өртөг 159.4 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 64 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол шилжих төсөл, арга хэмжээний тоо 5-аар, нийт төсөвт өртөг 18.6 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 12.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагджээ.

### **Хүснэгт 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих ба шилжих (тэрбум төгрөг)**

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ	50	79	<b>+29</b>	679.4	838.8	<b>+159.4</b>	519.9	583.9	<b>+64.0</b>
Шилжих төсөл, арга хэмжээ	48	53	<b>+5</b>	11,642.5	11,661.1	<b>+18.60</b>	1,148.8	1,161.6	<b>+12.8</b>
Нийт	98	132	<b>+34</b>	12,321.9	12,499.9	<b>+178.0</b>	1,668.7	1,745.5	<b>+76.8</b>

*Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв*

## ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

**Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн тоо 20-оор, нийт төсөвт өртөг 134.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 43 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 664 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 438.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 47 барилга байгууламж, 99.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 94.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 11 их засвар, 35.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 31.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 тоног төхөөрөмж, 40.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 19.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 зураг төсөв байна. Төсвийн төсөлтэй харьцуулахад шинээр

хэрэгжих барилга байгууламжийн тоо 20-оор, нийт төсөвт өртөг 134.4 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 43 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Мөн шинээр хэрэгжих их засварын тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 15.9 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 15.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Шинээр хэрэгжих тоног төхөөрөмжийн тоо 2-оор, нийт төсөвт өртөг 2.5 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 0.5 тэрбум төгрөгөөр, шинээр хэрэгжих зураг төсвийн тоо 6-аар, нийт төсөвт өртөг 6.8 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 4.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагджээ.

### **Хүснэгт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)**

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Барилга байгууламж	27	47	+20	529.6	664.0	+134.4	395.2	438.2	+43.0
Их засвар	10	11	+1	83.6	99.5	+15.9	78.3	94.1	+15.8
Тоног төхөөрөмж	10	12	+2	32.8	35.3	+2.5	31.1	31.6	+0.5
Зураг төсөв	3	9	+6	33.3	40.1	+6.8	15.3	19.9	+4.6

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан төсөл, арга хэмжээний тоо 17-оор, нийт төсөвт өртөг 148.9 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 57.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийг зориулалтаар нь авч үзвэл хот байгуулалт, барилга стандарт, хяналт, зохицуулалтад 354.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 321.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 20 төсөл, арга хэмжээ батлагджээ. Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад, 337.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 133 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 40 төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээнд 74.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ хэрэгжих бол Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжид 35.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 24.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Мөн цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудууд 7.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжид 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний

уст цэгийн төлөвлөлтөд 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан.

Төсвийн төсөлтэй харьцуулахад хот байгуулалт, барилга стандарт, хяналт, зохицуулалтад зориулагдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 6-аар нэмэгдсэн ч нийт төсөвт өртөг 17.2 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 21.4 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна. Харин нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 17-оор, нийт төсөвт өртөг 148.9 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 57.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ. Мөн орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээнд зориулагдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн 15 тэрбум төгрөгөөр, Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжийн шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн 7.3 тэрбум төгрөгөөр, Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн 3.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан.

**Хүснэгт 4. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, зориулалтаар (тэрбум төгрөг)**

Зориулалт	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт	14	20	+6	372.1	354.9	-17.2	342.7	321.3	-21.4
Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт	23	40	+17	188.9	337.8	+148.9	75.4	133.0	+57.6
Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ	3	4	+1	59.8	74.8	+15.0	59.8	74.8	+15.0
Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж	3	4	+1	31.3	35.2	+3.9	20.3	24.2	+3.9
Цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудуу	1	1	-	7.8	7.8	-	3.9	3.9	-
Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламж	2	4	+2	5.2	12.5	+7.3	5.2	12.5	+7.3
Нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт	-	2	+2	-	1.6	+1.6	-	1.6	+1.6
Бусад	4	4	-	14.2	14.2	-	12.5	12.5	-

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд Хан-Уул дүүрэгт хэрэгжих шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 10-аар, нийт төсөвт өртөг 87.8 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 41.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийг байршлаар нь авч үзвэл 450.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 427.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 31 төсөл, арга хэмжээ Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжинэ. Хан-Уул дүүрэгт 110.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 54 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээ, Баянзүрх дүүрэгт 83.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 34.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр батлагдсан. Сонгинохайрхан дүүрэгт 66.1 тэрбум төгрөгийн

төсөвт өртөгтэй, 19.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ, Сүхбаатар дүүрэгт 63.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 21 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээ, Баянгол дүүрэгт 34.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 17.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Багануур дүүрэгт 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ, Налайх дүүрэгт 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ Налайх дүүрэгт тус тус хэрэгжинэ. Түүнчлэн 25.8 тэрбум төгрөгийн төсөвт

өртөгтэй, 7.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэг, Яармаг, Амгалан, Баянхошуу, Чингэлтэй хотод хэрэгжихээр батлагджээ.

Төсвийн төсөлтэй харьцуулахад Хан-Уул дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо,

төсөвт өртөг, 2026 онд санхүүжих дүнд хамгийн өндөр дүнтэй өөрчлөлт орж батлагдсан байна. Тухайлбал, Хан-Уул дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 10-аар, нийт төсөвт өртөг 87.5 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 41.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.

**Хүснэгт 5. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, байршлаар (тэрбум төгрөг)**

Байршил	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Улаанбаатар*	24	31	+7	433.1	450.6	+17.5	429.5	427.6	-1.9
Хан-Уул дүүрэг	3	13	+10	22.8	110.6	+87.8	12.2	54.0	+41.8
Баянзүрх дүүрэг	9	12	+3	67.7	83.5	+15.8	27.9	34.1	+6.2
Сонгинохайрхан дүүрэг	4	7	+3	60.8	66.1	+5.3	14.1	19.5	+5.4
Сүхбаатар дүүрэг	6	8	+2	56.4	63.5	+7.1	17.4	21.0	+3.6
Баянгол дүүрэг	2	4	+2	10.0	34.3	+24.3	10.0	17.3	+7.3
Сонгинохайрхан дүүрэг, Яармаг, Амгалан, Баянхошуу, Чингэлтэй хот	1	1	-	25.8	25.8	-	7.7	7.7	-
Багануур дүүрэг	1	1	-	2.9	2.9	-	1.0	1.0	-
Налайх дүүрэг	-	2	+2	-	1.6	+1.6	-	1.6	+1.6

\*Тодорхой байршил заагаагүй эсвэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд  
Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Нийслэлийн төсвийн төсөлд тусгаагүй хөрөнгө оруулалтын 29 төсөл, арга хэмжээг ИТХ-аас нэмж баталжээ.**

Нийслэлийн төсвийн төсөлд тусгаагүй байсан ч нэмж батлагдсан шинээр хэрэгжих нийт 190.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 97.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 29 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 1). Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй төслүүдийг дурдвал, 24 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Хан-Уул дүүргийн 23 дугаар хорооны сургуулийн барилга, 19 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 9.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны 640 суудалтай сургуулийн барилга,

18 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны сургуулийн барилга, 16.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Төрсний дараах эх, нярайн сэргээн засах, асаргааны төвийн барилга, 15 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй нийтийн зориулалттай орон сууцны барилгын засварын ажил, 12.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 4.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Баянгол дүүргийн 141 дүгээр сургуулийн барилгын өргөтгөл төслүүд багтаж байна.

## **Нийслэлийн төсвийн төсөлд туссан төсөвт өртөг эсвэл санхүүжих дүнд өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ байна.**

Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг эсвэл санхүүжих дүнд өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд, Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговрын төсөвт өртөг ба санхүүжих дүн 34.3 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан бол гэрлэх ёслолын

ордон ОНӨААТҮГ-ын дэвээр, танхимыг шинэчлэх ажлын төсөвт өртөг ба санхүүжих дүн 847 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Мөн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны Аддиктологийн төвийн тоног төхөөрөмжийн төсөвт өртөг 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.

## **Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 14 төсөл, арга хэмжээний эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна.**

Төсвийн тухай хуулийн “29.3.5 Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэн заалтын дагуу эхний санхүүжилт буюу 2026 онд санхүүжих дүнг хуулийн дагуу төлөвлөөгүй нийт 14 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 3). Үүнд: 2 жилийн хугацаанд хэрэгжих, эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 50 хувиас бага 4 төсөл, арга хэмжээ, 3 жилийн хугацаанд хэрэгжих, эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 33.3 хувиас бага 10 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 14 төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжвэл зохих 65.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 44.5 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ. Санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд Баянзүрх дүүргийн 26-р хороонд хэрэгжих 640 суудалтай сургуулийн барилга, 36 дугаар хороонд хэрэгжих 240 ортой цэцэрлэгийн барилга, 14-р хороонд хэрэгжих цэцэрлэгийн

барилга, 43 дугаар хорооны хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга худалдан авах төсөл, арга хэмжээнүүд багтаж байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 23-р хороонд хэрэгжих 640 суудалтай сургуулийн барилга, Багануур дүүргийн 1-р хорооны эрүүл мэндийн төвийн барилгын дотор засварын ажил, Баянгол дүүргийн 24 дүгээр хорооны сургуулийн барилга худалдан авах, Хан-Уул дүүргийн 23-р хороонд хэрэгжих 240 ортой цэцэрлэгийн барилгын төсөл, арга хэмжээнүүд багтжээ. Түүнчлэн Сэлбэ дэд төв, Баянголын аманд хэрэгжих 960 суудалтай сургуулийн барилга, Төрсний дараах эх, нярайн сэргээн засах, асаргааны төвийн барилга, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах ажил, Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн ажил, Байгаль орчны хяналтын нэгдсэн систем хангамжийн ажил санхүүжилтийн шаардлага хангахгүй байна.

## ӨМНӨХ ОНООС ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

**Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих зураг төсвийн тоо 2-оор, нийт төсөвт өртөг 150.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 18.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэхээр батлагдсан шилжих төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 45 барилга байгууламжид 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт, 4 их засварын ажилд 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2 тоног төхөөрөмжид 24.2 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2 зураг төсвийн ажилд 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тус

тус баталжээ. Төсвийн төсөлтэй харьцуулахад шилжих барилга байгууламжийн тоо 3-аар нэмэгдсэн ч нийт төсөвт өртөг 132.4 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 6.1 тэрбум төгрөгөөр буурч батлагджээ. Харин шилжих зураг төсвийн тоо 2-оор, нийт төсөвт өртөг 150.9 тэрбум төгрөгөөр, 2026 онд нийт санхүүжих дүн 18.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.

### Хүснэгт 6. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Барилга байгууламж	42	45	3	11,591.3	11458.9	-132.4	1,116.8	1110.7	-6.1
Их засвар	4	4	-	17.9	17.9	-	7.9	7.9	-
Тоног төхөөрөмж	2	2	-	33.3	33.3	-	24.2	24.2	-
Зураг төсөв	-	2	2	-	150.9	+150.9	-	18.9	+18.9

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг 12.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэхээр батлагдсан шилжих төсөл, арга хэмжээнүүдийг зориулалтаар нь авч үзвэл авто замын түгжрэлийг бууруулахад 2.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд 789.5 тэрбум төгрөгийн санхүүжилт, нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалтад 8.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд 127.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно. Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад 299.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөлд 103.2 тэрбум төгрөгийн

санхүүжилт, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжид 286.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд 66.8 тэрбум төгрөгийн санхүүжилт 2026 онд олгохоос гадна хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтад 107.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөлд 55.4 тэрбум төгрөгийн санхүүжилт 2026 онд олгохоор баталжээ. Мөн нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлтөд 25.6 тэрбум төгрөгийн төсөвт

өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт, нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжид, 6.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно. Түүнчлэн орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээнд 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд 0.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршилд 0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно.

Төсвийн төсөлтэй харьцуулахад нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг

12.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтад зориулагдсан шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр нийт төсөвт өртөг 4.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Түүнчлэн Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжид зориулагдсан төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 0.7 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 0.2 тэрбум төгрөгөөр, нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршилд зориулагдсан шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн 0.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагджээ.

**Хүснэгт 7. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, зориулалтаар (тэрбум төгрөг)**

Зориулалт	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Авто замын түгжрэлийг бууруулах	1	1	-	2,384.00	2,384.0	-	780.7	789.5	8.8
Нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт	2	2	-	8,533.70	8,533.7	-	127.6	127.6	-
Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт	22	24	2	286.7	299.1	12.4	101.2	103.2	2.0
Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламж	5	6	1	285.5	286.2	0.7	66.6	66.8	0.2
Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт	10	11	1	102.2	107.1	4.9	54.1	55.4	1.3
Нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт	2	2	-	25.6	25.6	-	7.5	7.5	-
Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж	2	2	-	6.9	6.9	-	3.3	3.3	-
Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ	1	1	-	1.8	1.8	-	0.4	0.4	-
Нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршил	-	1	1		0.5	0.5		0.5	-
Бусад	3	3	-	16.1	16.1	-	7.5	7.5	-

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Төсвийн төсөлтэй харьцуулахад Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүргүүдэд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн нэмэгдэж батлагджээ.**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэхээр батлагдсан шилжих төсөл, арга хэмжээнүүдийг байршлаар нь авч үзвэл 11.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 14 төсөл, арга хэмжээ тодорхой дүүрэг заагаагүй буюу Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжинэ. 79 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 28 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ Хан-Уул дүүрэгт, 59.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 19.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ Баянзүрх дүүрэгт батлагдсан байна. Мөн 55.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 22 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ Баянгол дүүрэгт, 47.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 23.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжинэ. 39.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 11.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээ Сүхбаатар дүүрэгт, 28 тэрбум

төгрөгийн төсөвт өртөгтэй, 9.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ Чингэлтэй дүүрэгт хэрэгжинэ. Түүнчлэн 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ Багануур дүүрэгт, 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 0.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ Налайх дүүрэгт хэрэгжихээр батлагджээ. Төсвийн төсөлтэй харьцуулахад Сүхбаатар дүүрэгт хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг 6.2 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1.5 тэрбум төгрөгөөр, Чингэлтэй дүүрэгт хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 6.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1 тэрбум төгрөгөөр, Налайх дүүрэг хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 0.7 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 0.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан байна.

**Хүснэгт 8. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, байршлаар (тэрбум төгрөг)**

Байршил	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Улаанбаатар*	13	14	+1	11,334.5	11339.5	+5.0	1,033.6	1043.7	+10.1
Хан-Уул дүүрэг	7	7	-	79.0	79.0	-	28.0	28.0	-
Баянзүрх дүүрэг	7	7	-	59.3	59.3	-	19.1	19.1	-
Баянгол дүүрэг	4	4	-	55.7	55.7	-	22.0	22.0	-
Сонгинохайрхан дүүрэг	10	10	-	47.5	47.9	+0.4	23.6	23.6	-
Сүхбаатар дүүрэг	3	5	+2	33.1	39.3	+6.2	10.1	11.6	+1.5
Чингэлтэй дүүрэг	2	3	+1	21.6	28.0	+6.4	8.9	9.9	+1.0
Багануур дүүрэг	2	2	-	11.7	11.7	-	3.5	3.5	-
Налайх	-	1	+1	-	0.7	+0.7	-	0.2	+0.2

\*Тодорхой байршил заагаагүй эсвэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд  
Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Нийслэлийн төсвийн төсөлд тусаагүй боловч 2026 онд санхүүжүүлэхээр нэмэгдэж батлагдсан 5 шилжих төсөл, арга хэмжээ байна.**

Нийслэлийн төсвийн төсөлд тусгаагүй байсан ч 2016 онд санхүүжүүлэхээр нэмж батлагдсан 5 шилжих төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 2). Үүнд, 6.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ажлын дуусгал, 5.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны Сургуулийн барилга ажлын дуусгал, 0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны Хайлааст Дарь-Эхийг холбосон замаас хойш Сэлбэ дэд төвийн зам руу холбогдох шинэ авто замын нэмэлт

ажил, 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба 0.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Налайх дүүргийн Плэйтийм аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх цахилгааны ажил, 5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба 1.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй тархмал дулааны эрчим хүчний хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболтын нэгдсэн судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, хийн түлшний тухай шинэ хууль, дүрэм, журам, норм, норматив, стандартыг боловсруулах, иргэд олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх туслан дэмжих техник туслалцааны зөвлөх үйлчилгээ төсөл багтаж байна.

**Нийслэлийн төсвийн төсөлд туссан төсөвт өртөгт өөрчлөлт орж батлагдсан 1 шилжих төсөл, арга хэмжээ байна.**

Төсвийн төсөлд туссан төсөвт өртөгт өөрчлөлт орж батлагдсан 1 шилжих төсөл, арга хэмжээ байна. Үүнд, Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны Хороо, өрхийн эмнэлэг,

цагдаагийн хэсгийн цогцолбор барилгын төсөвт өртөг 310 сая төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.

## НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

**Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 248.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 50 шинэ төсөлд 2026 онд 173.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.**

Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 248.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 173.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй шинээр хэрэгжих 50 төсөл, арга хэмжээ батлагджээ. Үүнээс 167.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 101.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 21 төсөл арга хэмжээ нь авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлтэд, 50.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 15 төсөл, арга хэмжээ нь авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтад, 26.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 12.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 12 төсөл,

арга хэмжээ нь борооны ус зайлуулах шугамд зориулагдана. Төсвийн төсөлтэй харьцуулахад авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлтэд зориулсан төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн 4.7 тэрбум төгрөгөөр, авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтад зориулсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг ба нийт санхүүжих дүн 4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан байна.

Мөн Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8 шилжих төсөл, арга хэмжээнд 2026 онд 54.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно.

### Хүснэгт 9. Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

Зориулалт	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлт	19	21	+2	163.0	167.7	+4.7	101.8	106.5	+4.7
Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт	15	15	-	46.6	50.6	+4.0	46.6	50.6	+4.0
Борооны ус зайлуулах шугам	12	12	-	26.5	26.5	-	12.6	12.6	-
Бусад	2	2	-	3.8	3.8	-	3,780.0	3.8	-
<b>Нийт</b>	<b>48</b>	<b>50</b>	<b>+2</b>	<b>239.9</b>	<b>248.6</b>	<b>+8.7</b>	<b>164.8</b>	<b>173.5</b>	<b>+8.7</b>

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8 шилжих төсөлд 54.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.**

Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 54.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 8 шилжих төсөл, арга хэмжээг

санхүүжүүлнэ. Төсвийн төсөлтэй харьцуулахад эдгээр шилжих төсөл, арга хэмжээнд 2026 онд олгох санхүүжилтийн дүн 8.7 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна.

## НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 3 шилжих төсөл, арга хэмжээнд 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаар төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд нийт 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүн 3 шилжих төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Эдгээрт 59.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 28 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн

ажил, 293.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 5.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Эрчим хүч хуримтлуурын станцын ажил, 1.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын төслүүд багтаж байна.

**Хүснэгт 10. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2026 онд олгох санхүүжилтийн дүн
1	Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил (Улаанбаатар хот)	2024	2026	59.1	28.0
2	Эрчим хүч хуримтлуурын станцын ажил	2024	2026	293.6	5.1
3	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол	2024	2026	1,646.2	1,267.9
	<b>Нийт</b>			<b>1,998.8</b>	<b>1,301.0</b>

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

## НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ТӨСЛҮҮД

**Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталжээ.**

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд нийт 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх төлөвлөсөн. Эдгээр төсөл, арга хэмжээнүүд нь бүгд 2026 ондоо багтаж дуусах ба бүрэн санхүүжигдэнэ. Үүнд, 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ Баянзүрх дүүрэгт, 3.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт, 2.3

тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээ Хан-Уул дүүрэгт, 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ Баянгол дүүрэгт, 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ Чингэлтэй дүүрэгт, 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ Налайх дүүрэгт, 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ Багануур дүүрэгт, 0.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ Багахангай дүүрэгт тус тус хэрэгжинэ.

### **Хүснэгт 11. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)**

№	Байршил	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2026 онд олгох санхүүжилтийн дүн
1	Баянзүрх дүүрэг	11	3.9	3.9
2	Сонгинохайрхан дүүрэг	12	3.6	3.6
3	Хан-Уул дүүрэг	10	2.3	2.3
4	Баянгол дүүрэг	11	2.0	2.0
5	Сүхбаатар дүүрэг	9	1.6	1.6
6	Чингэлтэй дүүрэг	4	1.6	1.6
7	Налайх дүүрэг	9	0.8	0.8
8	Багануур дүүрэг	3	0.8	0.8
9	Багахангай дүүрэг	1	0.4	0.4
	<b>Нийт</b>		<b>17.0</b>	<b>17.0</b>

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

## ОН ДАМЖИН САНХҮҮЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

**2025–2026 он дамжин санхүүжих 318 төсөл, арга хэмжээг 761.3 тэрбум төгрөгөөр 2026 онд санхүүжүүлэхээр баталжээ.**

2025-2026 он дамжин санхүүжих нийт 12.84 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 318 төсөл, арга хэмжээг 2026 онд 761.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Үүнээс 12.82 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 749.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 288 төсөл,

арга хэмжээг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 18.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 12.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 30 төсөл, арга хэмжээг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлнэ.

### Хүснэгт 12. 2025–2026 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг			2026 онд олгох санхүүжилтийн дүн		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Өөрчлөлт
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	291	288	-3	10,704.1	12,829.4	+2,125.3	749.1	749.2	+0.1
Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	30	30	-	18.4	18.4	-	12.2	12.1	-0.1
<b>Он дамжих нийт дүн</b>	<b>321</b>	<b>318</b>	<b>-3</b>	<b>10,722.5</b>	<b>12,847.8</b>	<b>+2125.3</b>	<b>761.3</b>	<b>761.3</b>	<b>-</b>

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл, Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

## ТОЙМ ДҮГНЭЛТ

- Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 34-өөр, нийт төсөвт өртөг 178 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох санхүүжилтийн дүн 76.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.
- Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн тоо 20-оор, нийт төсөвт өртөг 134.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 43 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан төсөл, арга хэмжээний тоо 17-оор, нийт төсөвт өртөг 148.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 57.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.
- Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд Хан-Уул дүүрэгт хэрэгжих шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 10-аар, нийт төсөвт өртөг 87.8 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 41.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.
- Нийслэлийн төсвийн төсөлд тусаагүй боловч шинээр хэрэгжихээр нэмэгдэж батлагдсан 29 төсөл, арга хэмжээ байна.
- Нийслэлийн төсвийн төсөлд туссан төсөвт өртөг эсвэл санхүүжих дүнд өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ байна.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 14 төсөл, арга хэмжээний эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна.
- Төсвийн төсөлтэй харьцуулахад Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих зураг төсвийн тоо 2-оор, нийт төсөвт өртөг 150.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 18.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад зориулагдсан шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг 12.4 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох санхүүжилтийн дүн 2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.
- Төсвийн төсөлтэй харьцуулахад Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүргүүдэд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн нэмэгдэж батлагджээ.
- Нийслэлийн төсвийн төсөлд тусаагүй боловч 2026 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр нэмэгдэж батлагдсан 5 шилжих төсөл, арга хэмжээ байна.
- Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 248.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 50 шинэ төсөл, арга хэмжээнд, 173.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.
- Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8 шилжих төсөл, арга хэмжээнд, 54.3 тэрбум төгрөгийн санхүүжилтолгоно.
- Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 3 шилжих төсөл, арга хэмжээнд 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.
- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар төсвийн төсөлд төлөвлөсний дагуу 2026 онд 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан.
- 2025-2026 он дамжин санхүүжих 318 төсөл, арга хэмжээг 761.3 тэрбум төгрөгөөр 2026 онд санхүүжүүлэхээр баталжээ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл
- Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Хавсралт 1. Нийслэлийн төсвийн төсөлд тусаагүй боловч шинээр хэрэгжихээр нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээнүүд (тэрбум төгрөг)**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Сургуулийн барилга худалдан авах (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо)	2028	24.0	8.0
2	Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо)	2028	19.0	9.5
3	Сургуулийн барилга худалдан авах (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо)	2028	18.0	6.0
4	Төрсний дараах эх, нярайн сэргээн засах, асаргааны төвийн барилга (Улаанбаатар хот)	2028	16.8	3.0
5	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын засварын ажил (Улаанбаатар хот)	2026	15.0	15.0
6	141 дүгээр сургуулийн барилгын өргөтгөл (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2028	12.8	4.3
7	Сургуулийн барилга худалдан авах (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо)	2028	9.5	3.0
8	Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн сургалтын төвийн одоогийн барилга байгууламжийг шинээр төлөвлөн нүүлгэн шилжүүлэх (Улаанбаатар хот)	2026	7.5	7.5
9	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга худалдан авах (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43 дугаар хороо)	2027	7.5	3.5
10	Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо)	2027	7.4	3.7
11	Гал түймэр унтраах аврах анги (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)	2028	7.1	2.4
12	Цэцэрлэгийн барилга худалдан авах (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо)	2027	7.0	3.5
13	Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 36 дугаар хороо)	2028	6.9	1.3
14	Гурван хогийн цэгийн хашааг шинэчлэх, засах ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо)	2026	6.7	6.7
15	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 240 ор (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)	2026	4.8	4.8
16	Барилгажилтын зураг төсөл боловсруулах /ТЭЗҮ зураг төсөл/, (Улаанбаатар хот)	2027	4.3	2.1
17	"Агро-Сити" туршилтын дөрвөн улирлын ухаалаг шилэн хүлэмжийн барилга (Улаанбаатар хот)	2027	4.0	2.0

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
18	Уулын зам дагуух явган болон дугуйн замын ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)	2026	3.9	3.9
19	Ахмад настанд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сувиллын төв (Богд-Уул сувилал)-ийн барилгын их засварын ажил (Улаанбаатар хот)	2027	2.9	1.4
20	"Гоожингийн өндөр" түүхийн дурсгалт барилгын засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо)	2026	1.4	1.4
21	Шинэ дулааны эх үүсгүүр 79 МВт-ын хүчин чадалтай дулааны станцын зураг төсөв (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2026	1.3	1.3
22	Гадна ариутгах татуургын шугам сүлжээний засвар, шинэчлэл (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо)	2026	0.9	0.9
23	Сургуулийн барилгын зураг төсөв (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 7, 15 дугаар сургууль)	2026	0.5	0.5
24	35/10 кВ-ын "Дашчойхор", "Яргайт" дэд станцаас 10 кВ-ын Цээнэ, "Гоодой" фидерийн ачаалал хөнгөлөх ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 20 дугаар хороо)	2026	0.5	0.5
25	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж техник хэрэгсэл (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2026	0.3	0.3
26	Арьс ширний үйлдвэрийн бүсийн хөрсний бохирдлыг нөхөн сэргээх аргачлал, суурь судалгаа (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо)	2026	0.3	0.3
27	Чандмань Налайх цэвэр усны станцын зураг төсөв (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2026	0.3	0.3
28	Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2026	0.2	0.2
29	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын зураг төсөв (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	2026	0.1	0.1

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Хавсралт 2. Нийслэлийн төсвийн төсөлд тусаагүй боловч 2026 онд санхүүжүүлэхээр нэмэгдэж батлагдсан шилжих төсөл, арга хэмжээнүүд (тэрбум төгрөг)**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо) ажлын дуусгал	2019	2027	6.3	1.0
2	Сургуулийн барилга, 320 суудал (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо) ажлын дуусгал	2019	2027	5.8	1.0
3	Хайлааст Дарь-Эхийг холбосон замаас хойш Сэлбэ дэд төвийн зам руу холбогдох шинэ авто замын нэмэлт ажил (СБД, 13 дугаар хороо)	2024	2026	0.5	0.5
4	Плэйтийм аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх цахилгааны ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2025	2026	0.7	0.2
5	Тархмал дулааны эрчим хүчний хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболтын нэгдсэн судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, хийн түлшний тухай шинэ хууль, дүрэм, журам, норм, норматив, стандартыг боловсруулах, иргэд олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх туслан дэмжих техник туслалцааны зөвлөх үйлчилгээ	2025	2026	5.0	1.3

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

**Хавсралт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжихээр батлагдсан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт (тэрбум төгрөг)**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	2026 онд санхүүжвэл зохих дүн	2026 онд дутуу төлөвлөсөн санхүүжилт
1	Сургуулийн барилга, 640 суудал (Баянзүрх дүүрэг, 26-р хороо)	2028	25.2	5.0	8.4	3.4
2	Сургуулийн барилга, 960 суудал (Сэлбэ дэд төв)	2028	25.2	5.0	8.4	3.4
3	Сургуулийн барилга, 960 суудал (Баянголлын ам)	2028	25.2	5.0	8.4	3.4
4	Сургуулийн барилга, 640 суудал (Сонгинохайрхан дүүрэг, 23-р хороо)	2028	25.0	5.0	8.3	3.3
5	Төрсний дараах эх, нярайн сэргээн засах, асаргааны төвийн барилга (Улаанбаатар хот)	2028	16.8	3.0	5.6	2.6
6	Цэцэрлэгийн барилга, 240 ор (Хан-Уул дүүрэг, 23-р хороо)	2028	6.9	1.3	2.3	1.0
7	Цэцэрлэгийн барилга, 240 ор (Баянзүрх дүүрэг, 36 дугаар хороо)	2028	6.9	1.3	2.3	1.0
8	Цэцэрлэгийн барилга (Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Консулын 6-9 дүгээр гудамж)	2028	7.8	1.7	2.6	0.9
9	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах	2028	25.8	7.7	8.6	0.9
10	Эрүүл мэндийн төвийн барилгын дотор засварын ажил (Багануур дүүрэг, 1 дүгээр хороо)	2027	2.9	1.0	1.4	0.4
11	Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн ажил	2027	2.5	0.8	1.2	0.4
12	Байгаль орчны хяналтын нэгдсэн систем хангамжийн ажил	2027	2.7	1.0	1.4	0.4
13	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга худалдан авах (Баянзүрх дүүрэг, 43 дугаар хороо)	2027	7.5	3.5	3.8	0.3
14	Сургуулийн барилга худалдан авах (Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо)	2028	9.5	3.0	3.2	0.2

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны батлагдсан төсөв

БОЛОВСРУУЛСАН: Судлаач Д.Баярмаа  
 ДУГААРЫГ ЭРХЭЛСЭН: Д.Оюунбадам,  
 ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн  
 менежер



НЭЭЛТТЭЙ  
 НИЙГЭМ  
 ФОРУМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240,  
 Сүхбаатар дүүрэг, Л.Түдэвийн гудамж-5/3  
 Утас: 976-76113207  
 Факс: 976-11-324857  
 Веб: <http://www.forum.mn>  
 И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)